



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ӨВА-2023/246/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Өвөрхангай аймаг, Арвайхээр сум 2023 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: О.Батжаргал Утас: 70323253 Цахим хаяг: Batjargalo@audit.gov.mn Аудитын менежер: Д.Гансүх Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com Аудитор: Р.Энхзул Утас: 70323108 Цахим хаяг: Enkhzulr@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Нэг.Хараат бус аудиторын дүгнэлт



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023.12.24 № 110
танай _____ -ны № _____ -г

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР,
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Т.НАРАНГАРАВ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өвөрхангай аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тус байгууллага нь 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлого 34,020.0 мянган төгрөг, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 810,695.3 мянган төгрөг, өмнөх оны үлдэгдэл 14,497.6 мянган төгрөг, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 2,150,974.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, хөтөлбөр арга хэмжээнд 1,981,464.3 мянган төгрөгийг зарцуулж, 1,028,722.8 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Шилэн дансны сайтад цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэрийг мэдээлээгүй.

015030580

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О. БАТЖАРГАЛ

D:\New Volume\2023 on\Bichig khereg\A4

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	/сая төгрөгөөр/	
		Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	2,238.01	2,731.10
33	АВЛАГА	2,238.01	2,731.10
33300	Татаас, санхүүжилтийн авлага	14.50	31.00
335	Бусад авлага	2,223.51	2,700.10
3352	Хувь хүмүүсээс авах авлага	2,223.51	2,700.10
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,238.01	2,731.10
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,238.01	2,731.10
51	Засгийн газрын хувь оролцоо	2,238.01	2,731.10
512	Хуримтлагдсан үр дүн	2,238.01	2,731.10
51210	Өмнөх үеийн үр дүн	2,238.01	2,218.29
51220	Тайлант үеийн үр дүн	-	512.81
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,238.01	2,731.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	/сая төгрөгөөр/	
		Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,063.43	2,184.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37.60	34.02
120	Нийтлэг татварын бус орлого	37.60	34.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37.60	34.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37.60	34.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,025.83	2,150.97
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,025.83	2,150.97
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10.53	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,015.30	2,150.97
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,232.36	1,672.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,232.36	1,672.18
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6.95	4.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5.95	4.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5.95	4.48
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,225.41	1,667.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	266.35	669.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	266.35	669.99
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	33.89	169.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	33.89	169.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6.36	34.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6.36	34.02
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	918.81	794.19
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	918.81	794.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(168.94)	512.81
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(168.94)	512.81

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,063.43	2,184.99
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	37.60	34.02
120	Нийтлэг татварын бус орлого	37.60	34.02
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	37.60	34.02
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	37.60	34.02
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,025.83	2,150.97
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,025.83	2,150.97
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10.53	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,015.30	2,150.97
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,679.18	3,010.19
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,679.18	3,010.19
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6.95	4.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5.95	4.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5.95	4.48
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,672.23	3,005.71
2132	Бусад урсгал шилжүүлэг	698.67	1,976.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	698.67	1,976.99
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	48.39	169.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	48.39	169.51
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	6.36	34.02
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	6.36	34.02
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	918.81	825.19
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	918.81	825.19
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(615.75)	(825.19)
14	Бусад эх үүсвэр	615.75	825.19
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	615.75	825.19
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	615.75	825.19
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	615.75	825.19

2.4 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,238.01	0.00	2,238.01
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00		0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,238.01	0.00	2,238.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт			0.00		0.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт			0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз			0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00		0.00
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,238.01	0.00	2,238.01
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,238.01	0.00	2,238.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-19.72	0.00	-19.72
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	2,218.29	0.00	2,218.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	512.81	0.00	512.81
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	2,731.10	0.00	2,731.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/сая төгрөгөөр/			
		Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,025.83	705.62	2,152.97	1,981.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,025.83	705.62	2,152.97	1,981.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	14.53	6.95	4.50	4.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13.53	5.95	4.50	4.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12.03	5.95	4.50	4.48
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1.50	-	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1.00	1.00	-	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1.00	1.00	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,011.30	698.67	2,148.47	1,976.99
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,011.30	698.67	2,148.47	1,976.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,011.30	698.67	2,148.47	1,976.99
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,035.83	653.36	2,167.97	3,010.19
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,025.83	-	2,152.97	2,150.97
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,025.83	-	2,152.97	2,150.97
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	10.00	653.36	15.00	859.21
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	615.75	-	825.19
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10.00	37.60	15.00	34.02

2.6 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн нэмэлт тайлан

Дансны код	Үзүүлэлт	/сая төгрөгөөр/	
		Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,981.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,981.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		4.48
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		4.48
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		4.48
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,976.99
2132	Бусад урсгал шилжүүлэг		1,976.99
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		1,976.99
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		2,150.97
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		2,150.97
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,150.97

Гурав. Аудитын илрүүлэлт

Тус байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар аудитаар Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хөрөнгө зарцуулахтай холбоотой 6 тушаал шийдвэрийг мэдээлээгүй зөрчил¹ илэрсэн.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудлаар 1 зөрчил илэрсэн.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн				
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил												
Дүн	1	938,0			1	938,0						
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил												
Дүн												
Нийт дүн	1	938,0			1	938,0						

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
	НИЙТ	1	1			1			

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2023 оны 02 дугаар сарын 24-ний өдөр

